



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 9/23

Мандалговь

Г Байгууллагын газар эзэмших , ашиглах

эрхийг үнэлэх үл хөдлөх хөрөнгийн дахин
үнэлгээ хийх ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 "а", Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын 1 болон 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны А-1/1694 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Байгууллагын газар эзэмших , ашиглах эрхийг үнэлэх үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэх ажлын хэсгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийг оролцуулан дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Цэнгэлмаа (Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Р.Лхагвадорж (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Л.Мягмарсүрэн (Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

С.Адъяасүрэн (Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Д.Нандинцэцэг (Нягтлан бодогч)

А.Цэгмэдбаатар (Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Хоёр. Ажлын хэсэг нь холбогдох баримт материалыг бүрдүүлэх, хөрөнгийн бодит байдлыг тогтоох, нэгдсэн дүгнэлт акт тайлбар бэлтгэн баталгаажуулах ажлын бэлтгэлийг ханган хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж дүнг 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн дотор аймгийн Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлын хэсэгт хүлээлгэж өгөхийг байгууллагын ажлын хэсэг (С.Цэнгэлмаа) -т үүрэг болгосугай



ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН

0300196

D:\Албан бичиг\2018 тушаал.docx